ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ХЭА-2022/27/НА-СТА-ТШ3

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2022 он | Аудитын газрын Дарга,<br>тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар<br>Утас: 70562112<br><br>Аудитын менежер: Д.Оюунтуяа<br>Утас: 99775390<br><br>Аудитор: Х.Еркегүл<br>Утас: 99040705 |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Аудитын санал, дүгнэлт ........ 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 1
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 1
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 2
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 3
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 4
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 5
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 6
3. Аудитын тайлан ........ 7
3.1 Ерөнхий зүйл ........ 7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 7
3.4 Материаллаг байдал ........ 8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 8
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 10
3.8 Аудитын гол асуудал ........ 10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 10
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 10
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 10
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 10
4. Аудитын илрүүлэлт ........ 11
4.2.1 Залруулсан алдаа ........ 11
4.2 .2 Төлбөрийн акт ........ 11
4.2.3 Албан шаардлага ........ 11
4.2.4 Зөвлөмж ........ 11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 12
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал ........ 12
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 12
6. Албан шаардлага ........ 16

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас:70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2022.03.03 № 68

танай ____________ -ны № ____________ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН
НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГА Д.ОЮУНГЭРЭЛ
ТАНАА

Аудитын санал дүгнэлт гаргах тухай

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭРДЭНЭБААТАР

02303008 4

E:/DOTOOD AJIL/БХ 2022/явсан бичиг/А4 20220303 68

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **353,809,149.14** | **3,720,400,815.29** |
| 31 | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 00.00 | 1,787,429.68 |
| 312 | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 00.00 | 1,787,429.68 |
| 3121 | **Төгрөг** | 00.00 | 1,787,429.68 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 00.00 | 734,324.43 |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | 00.00 | 1,053,105.25 |
| 33 | **АВЛАГА** | - | **2,653,485,215.30** |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 00.00 | 2,653,485,215.30 |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | **353,809,149.14** | **1,065,128,170.31** |
| 351 | **Түүхий эд материал** | 181,166,521.54 | 853,997,394.36 |
| 35130 | Эм боох материал | 181,166,521.54 | 853,997,394.36 |
| 354 | **Хангамжийн материал** | **158,182,627.60** | **194,395,775.95** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,569,400.00 | 4,258,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 29,052,265.00 | 50,547,655.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 28,508,550.00 | 42,965,636.15 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 453,870.00 | - |
| 35450 | Барилгын засварын материал | 32,076,850.00 | 29,335,650.00 |
| 35460 | Хүнсний материал | 1,882,490.00 | 1,727,752.20 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 63,639,202.60 | 65,560,582.60 |
| 35600 | Мал амьтад | 14,460,000.00 | 16,735,000.00 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **23,973,554,220.29** | **24,394,608,288.62** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **23,973,554,220.29** | **24,394,608,288.62** |
| 392 | **Биет хөрөнгө** | **23,100,260,191.13** | **23,523,441,309.50** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 20,405,117,281.00 | 20,405,117,281.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (1,015,685,965.08) | (1,378,966,246.92) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 265,999,999.97 | 279,699,999.97 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (142,747,499.93) | (166,385,208.18) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 7,631,079,581.13 | 9,365,869,402.31 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (4,111,404,776.65) | (5,031,195,169.10) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 281,123,883.27 | 303,470,883.27 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (213,222,312.58) | (254,169,632.85) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 11,771,636.10 | 11,771,636.10 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (11,771,636.10) | (11,771,636.10) |
| 393 | **Биет бус хөрөнгө** | **873,294,029.16** | **871,166,979.12** |
| 39301 | Програм хангамж | 16,078,700.00 | 16,078,700.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (5,984,670.84) | (8,111,720.88) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 863,200,000.00 | 863,200,000.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **24,327,363,369.43** | **28,115,009,103.91** |
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **1,466,621,362.33** |
| 41 | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 1,466,621,362.33 |
| 413 | **Өглөг** | **00.00** | **1,466,621,362.33** |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 00.00 | 718,162.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 00.00 | 1,398,338,810.33 |
| 4136 | **Бусад өглөг** | 00.00 | 67,564,390.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 00.00 | 67,564,390.00 |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **24,327,363,369.43** | **26,648,387,741.58** |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | **24,327,363,369.43** | **26,648,387,741.58** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 4,930,425,368.06 | 4,930,425,368.06 |
| 51101 | Өмч: - төрийн | 4,930,425,368.06 | 4,930,425,368.06 |
| 512 | **Хуримтлагдсан үр дүн** | **18,823,875,400.85** | **21,144,899,773.00** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 18,823,875,400.85 | 18,823,875,400.85 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 2,321,024,372.15 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 573,062,600.52 | 573,062,600.52 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **24,327,363,369.43** | **28,115,009,103.91** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **11,705,215,079.58** | **16,784,707,553.94** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,928,691,357.58** | **3,097,293,363.94** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 2,928,691,357.58 | 3,097,293,363.94 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 2,928,691,357.58 | 3,097,293,363.94 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 162,275,260.00 | 206,492,964.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 9,399,950.00 | 8,531,152.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 2,757,016,147.58 | 2,882,269,247.94 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **8,776,523,722.00** | **13,687,414,190.00** |
| 1310 | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 5,442,494,400.00 | 997,948,560.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 5,442,494,400.00 | 997,948,560.00 |
| 131002 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | - | - |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 122,984,590.00 | 1,104,579,704.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 10,000,000.00 | - |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,170,000.00 | 141,976,704.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 96,757,000.00 | 896,712,500.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 15,057,590.00 | 65,890,500.00 |
| 1340 | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 3,211,044,732.00 | 11,584,885,926.00 |
| 134003 | Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт | 3,211,044,732.00 | 11,584,885,926.00 |
| 2 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **9,830,128,603.91** | **14,463,683,181.79** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **9,830,128,603.91** | **14,463,683,181.79** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 9,808,070,605.45 | 13,977,315,348.79 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **5,033,257,078.38** | **5,984,709,935.00** |
| 210101 | Үндсэн цалин | 2,638,612,989.75 | 2,945,211,606.00 |
| 210102 | Нэмэгдэл | 1,797,288,286.70 | 2,267,791,903.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 213,287,173.00 | 214,352,443.00 |
| 210104 | Урамшуулал | 384,068,628.93 | 557,353,983.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **657,793,057.54** | **786,259,118.99** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 464,763,413.37 | 569,223,097.51 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 48,678,147.44 | 54,537,849.52 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 38,922,517.97 | 43,630,559.81 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 9,584,470.78 | 10,805,855.39 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 95,844,507.98 | 108,061,756.76 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **719,048,407.00** | **847,247,925.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 97,586,493.00 | 109,577,457.00 |
| 210302 | Түлш, халаалт | 508,629,986.00 | 592,264,966.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 112,831,928.00 | 145,405,502.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | **178,515,113.00** | **254,259,037.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 32,700,190.00 | 33,569,469.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 78,552,710.00 | 114,978,510.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,693,754.00 | 11,207,719.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 9,120,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 51,448,459.00 | 94,503,339.00 |
| 2105 | **Нормативт зардал** | **1,905,745,558.59** | **4,486,030,029.51** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,673,765,878.59 | 4,111,716,911.71 |
| 210502 | Хоол, хүнс | 209,602,580.00 | 362,668,497.80 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 22,377,100.00 | 11,644,620.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **42,526,210.00** | **102,236,312.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 6,236,600.00 | 22,026,680.00 |
| 210604 | Урсгал засвар | 36,289,610.00 | 80,209,632.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | **12,853,837.00** | **20,365,398.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 12,853,837.00 | 20,365,398.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **12,800,811.00** | **13,256,295.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,482,311.00 | 8,230,724.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 990,000.00 | 2,000,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,012,500.00 | 803,700.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 176,000.00 | 363,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 140,000.00 | 1,858,871.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,245,530,532.94** | **1,482,951,298.29** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,110,000.00 | 14,460,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 810,000.00 | - |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 1,234,610,532.94 | 1,468,491,298.29 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **22,057,998.46** | **486,367,833.00** |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | **10,975,152.00** | **486,367,833.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,975,152.00 | 486,367,833.00 |
| 2133 | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **11,082,846.46** | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 11,082,846.46 | - |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **1,875,086,475.67** | **2,321,024,372.15** |
| 5 | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **1,875,086,475.67** | **2,321,024,372.15** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 4,930,425,368.06 | 573,062,600.52 | 16,490,916,382.81 | - | 21,994,404,351.39 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **4,930,425,368.06** | **573,062,600.52** | **16,490,916,382.81** | - | 21,994,404,351.39 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз | - | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 458,762,391.12 | - | 458,762,391.12 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **4,930,425,368.06** | **573,062,600.52** | **18,823,875,400.85** | - | **24,327,363,369.43** |
| D01 | **2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **4,930,425,368.06** | **573,062,600.52** | **18,823,875,400.85** | - | **24,327,363,369.43** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **4,930,425,368.06** | **573,062,600.52** | **18,823,875,400.85** | - | **24,327,363,369.43** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз | - | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 2,321,024,372.15 | - | 2,321,024,372.15 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **4,930,425,368.06** | **573,062,600.52** | **21,144,899,773.00** | - | **26,648,387,741.58** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **8,948,198,932.00** | **11,248,953,090.70** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **171,675,210.00** | **215,024,116.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 171,675,210.00 | 215,024,116.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 171,675,210.00 | 215,024,116.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 162,275,260.00 | 206,492,964.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 9,399,950.00 | 8,531,152.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **8,776,523,722.00** | **11,033,928,974.70** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 5,442,494,400.00 | 997,948,560.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 5,442,494,400.00 | 997,948,560.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 122,984,590.00 | 1,104,579,704.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 10,000,000.00 | - |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,170,000.00 | 141,976,704.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 96,757,000.00 | 896,712,500.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 15,057,590.00 | 65,890,500.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 3,211,044,732.00 | 8,931,400,710.70 |
| 134003 | Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт | 3,211,044,732.00 | 8,931,400,710.70 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **8,615,054,452.00** | **11,103,391,272.02** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **8,615,054,452.00** | **11,103,391,272.02** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **8,584,525,173.54** | **10,602,738,439.02** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 5,033,257,078.38 | 5,982,971,330.00 |
| 210101 | Үндсэн цалин | 2,638,612,989.75 | 2,943,473,001.00 |
| 210102 | Нэмэгдэл | 1,797,288,286.70 | 2,267,791,903.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 213,287,173.00 | 214,352,443.00 |
| 210104 | Урамшуулал | 384,068,628.93 | 557,353,983.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 659,221,299.56 | 787,279,561.99 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 466,191,655.39 | 570,243,540.51 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 48,678,147.44 | 54,537,849.52 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 38,922,517.97 | 43,630,559.81 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 9,584,470.78 | 10,805,855.39 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 95,844,507.98 | 108,061,756.76 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 719,048,407.00 | 828,972,244.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 97,586,493.00 | 109,577,457.00 |
| 210302 | Түлш, халаалт | 508,629,986.00 | 580,478,119.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 112,831,928.00 | 138,916,668.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 152,398,223.00 | 212,419,117.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 19,236,600.00 | 24,623,969.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 78,945,200.00 | 114,524,640.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,693,754.00 | 11,207,719.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 10,697,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 36,825,669.00 | 62,062,789.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,922,571,737.60 | 2,633,057,231.03 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,683,636,957.60 | 2,320,162,659.03 |
| 210502 | Хоол, хүнс | 208,804,580.00 | 306,096,572.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 30,130,200.00 | 6,798,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 58,512,310.00 | 107,588,462.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 10,052,000.00 | 27,546,000.00 |
| 210602 | Тавилга | 210,000.00 | - |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 2,352,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 45,898,310.00 | 80,042,462.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 12,853,837.00 | 20,365,398.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 12,853,837.00 | 20,365,398.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 25,852,281.00 | 30,085,095.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,482,311.00 | 15,228,724.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 990,000.00 | 2,000,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,012,500.00 | 803,700.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 176,000.00 | 363,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 525,000.00 | 3,024,871.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 12,666,470.00 | 8,664,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 810,000.00 | - |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 810,000.00 | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **30,529,278.46** | **500,652,833.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 19,446,432.00 | 500,652,833.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 19,446,432.00 | 500,652,833.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 11,082,846.46 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 11,082,846.46 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **333,144,480.00** | **145,561,818.68** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **333,144,480.00** | **143,774,389.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **333,144,480.00** | **143,774,389.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 333,144,480.00 | 143,774,389.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 333,144,480.00 | 143,774,389.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(333,144,480.00)** | **(143,774,389.00)** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | 1,787,429.68 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 1,787,429.68 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **12,642,910,600.00** | **10,143,639,062.27** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **12,642,910,600.00** | **10,143,639,062.27** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **12,636,710,600.00** | **10,133,541,878.27** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **5,833,908,900.00** | **5,833,334,460.00** |
| 210101 | Үндсэн цалин | 2,882,410,900.00 | 2,943,473,001.00 |
| 210102 | Нэмэгдэл | 2,302,737,400.00 | 2,267,791,903.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 225,225,000.00 | 214,352,443.00 |
| 210104 | Урамшуулал | 423,535,600.00 | 407,717,113.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **854,435,700.00** | **770,439,439.24** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 645,050,900.00 | 554,824,995.76 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 52,346,200.00 | 54,171,683.52 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 41,876,920.00 | 43,337,626.81 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 10,469,280.00 | 10,736,539.39 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 104,692,400.00 | 107,368,593.76 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **874,161,600.00** | **828,972,244.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 112,941,900.00 | 109,577,457.00 |
| 210302 | Түлш, халаалт | 585,695,800.00 | 580,478,119.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 175,523,900.00 | 138,916,668.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | **250,400,218.00** | **198,275,037.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 20,621,729.00 | 20,004,529.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 103,000,000.00 | 105,000,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 10,723,200.00 | 11,207,719.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 20,150,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 95,905,289.00 | 62,062,789.00 |
| 2105 | **Нормативт зардал** | **4,662,523,782.00** | **2,381,005,499.03** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 4,349,770,582.00 | 2,072,822,779.03 |
| 210502 | Хоол, хүнс | 268,412,200.00 | 301,384,720.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 44,341,000.00 | 6,798,000.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **122,440,300.00** | **84,793,430.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 20,000,000.00 | 28,813,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 6,500,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 95,940,300.00 | 55,980,430.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | **19,030,100.00** | **20,365,398.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 19,030,100.00 | 20,365,398.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **19,810,000.00** | **16,356,371.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 1,500,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,250,000.00 | 803,700.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 500,000.00 | - |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 780,000.00 | 363,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,000,000.00 | 3,024,871.00 |
| 210807 | Газрын төлбөр | 280,000.00 | - |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 200,000.00 | - |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 12,800,000.00 | 8,664,800.00 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **6,200,000.00** | **10,097,184.00** |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | **6,200,000.00** | **10,097,184.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,200,000.00 | 10,097,184.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **12,642,910,600.00** | **10,144,373,386.70** |
| 1310 | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **997,948,700.00** | **997,948,560.00** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 997,948,700.00 | 997,948,560.00 |
| 1340 | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **11,411,108,600.00** | **8,931,400,710.70** |
| 134003 | Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт | 11,411,108,600.00 | 8,931,400,710.70 |
| 120004 | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **233,853,300.00** | **215,024,116.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 228,159,000.00 | 206,492,964.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,694,300.00 | 8,531,152.00 |
| 5 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 734,324.43 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,103,526,598.75** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,103,526,598.75** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **612,970,949.75** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **149,636,870.00** |
| 210104 | Урамшуулал | 149,636,870.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **16,840,122.75** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 15,418,544.75 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 366,166.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 292,933.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 69,316.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 693,163.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **14,144,080.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 4,619,440.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,524,640.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **252,051,732.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 247,339,880.00 |
| 210502 | Хоол, хүнс | 4,711,852.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **166,569,421.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 138,317,389.00 |
| 210602 | Тавилга | 4,190,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 24,062,032.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **13,728,724.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 13,728,724.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **490,555,649.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **490,555,649.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 490,555,649.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | - |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,104,579,704.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **1,104,579,704.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 141,976,704.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 896,712,500.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 65,890,500.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | **1,053,105.25** |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Еркегүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 01/54 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Нэгдсэн эмнэлэг нь 10 мянгаас доошгүй суурин хүн ам бүхий суманд эрүүл мэндийн анхан шатны болон таваас доошгүй үндсэн мэргэшлээр лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээг, аймгийн төв, дүүрэгт долоогоос доошгүй үндсэн мэргэшлээр лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээг амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх чиг үүрэгтэй үйл ажиллагаа явуулдаг, Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 9,830.1 сая төгрөгөөс 1 хувиар буюу 98.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 68.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж үзэхэд тайлант онд нийт зардал буурсан тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Нэгдсэн эмнэлгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,787.6 сая төгрөгөөр буюу 15.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1.0 | 2.0 | 3=2-1 |
| **Мөнгөн хөрөнгө** | - | 1,787.4 | 1,787.4 |
| **Авлага** | - | 2,653,485.2 | 2,653,485.2 |
| **Урьдчилгаа** | - | - | - |
| **Бараа материал** | 353,809.1 | 1,065,128.2 | 711,319.0 |
| **Үндсэн хөрөнгө** | 23,973,554.2 | 24,394,608.3 | 421,054.1 |
| **Нийт хөрөнгө** | **24,327,363.4** | **28,115,009.1** | **3,787,645.7** |
| **Өр төлбөр** | - | 1,466,621.4 | 1,466,621.4 |
| **Засгийн газрын сан /Орон нутгийн сан** | 4,930,425.4 | 4,930,425.4 | - |
| **Өмнөх үеийн үр дүн** | 18,823,875.4 | 18,823,875.4 | - |
| **Тайлант оны үр дүн** | | 2,321,024.4 | 2,321,024.4 |
| **Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү** | 573,062.6 | 573,062.6 | - |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **24,327,363.4** | **28,115,009.1** | **3,787,645.7** |
| **Нийт орлого /Үр дүнгийн тайлан** | **11,705,215.1** | **16,784,707.6** | **5,079,492.5** |
| **Нийт зардал /Үр дүнгийн тайлан** | **9,808,070.6** | **13,977,315.3** | **4,169,244.7** |

Мөнгөн хөрөнгийн 1.8 сая төгрөгийн үлдэгдэл нь тухайн байгууллагын үлдэгдлийг тайлант хугацаанд төвлөрүүлээгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 2,653.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд эрүүл мэндийн даатгалын сангаас короновируст халдварын санхүүжилт орж ирээгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,065.1 сая төгрөг болж 711.3 сая төгрөгөөр өссөн нь халдварт өвчний үед хэрэглэх эм, хамгаалах хэрэгслийн нөөц бүрдүүлж ажиллаж байгаатай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 24,394.6 сая төгрөг болж 421.0 сая төгрөгөөр өссөн. Тайлант онд хандив болон дээд шатны байгууллагаас 1,733.3 сая төгрөгийн үнэ төлбөргүй

үндсэн хөрөнгө шилжиж ирсэн, батлагдсан төсвөөс 156.2 сая төгрөгийн хөрөнгө худалдаж авсан, 118.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө акталж данснаас хассан байна.

Засгийн газрын сан дансны үлдэгдэл 2,930.4 сая төгрөг байна. Тайлант онд өөрчлөлт ороогүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 16,784.7 сая төгрөг болж, өмнөх оноос 5,079.5 сая төгрөгөөр буюу 43.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгийн санхүүжилт өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал 14,463.7 сая төгрөг болж, өмнөх оноос 4,633.5 сая төгрөгөөр буюу 47.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалингийн зардал, нормативт зардал, бараа үйлчилгээний бусад зардал өссөнтэй холбоотой байна. Энэ нь короновируст халдварын дэгдэлттэй холоотой илүү цагийн хөлс, урамшуулал, эм эмнэлгийн хэрэгсэл, хоол, эмч ажилчдад олгосон нэг удаагийн тэтгэмж, урамшуулал зэрэг зардлууд өссөнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тайлант онд улсын төсвөөс 997.9 сая төгрөг, нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт 11,411.1 сая төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 233.8 сая төгрөг, нийт 12,642.9 сая төгрөгийн санхүүжилт баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвөөс 997.9 сая төгрөг, эмнэлгүүдэд олгох санхүүжилт 8,931.4 сая төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 215.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, үүнээс урсгал үйл ажиллагаанд 10,143.6 сая төгрөгийг зарцуулж, гүйцэтгэл 80.2 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тухайн байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас короновируст халдварын дархлаажуулалтын вакцины санхүүжилт 30.0 сая төгрөг, тоног төхөөрөмж авах 15.0 сая төгрөг, PCR-ын тандалт сорьцын санхүүжилт 386.0, эрүүл мэндийн ажилчдад олгох нэг удаагийн тэтгэмж 465.7 сая төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ашиглагдаагүй нөөц хөрөнгөөс 142.0 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны

хүрээнд бий болсон нэмэлт орлого 65.9 сая төгрөг, нийт 1,104.6 сая төгрөгийн орлого бүрдүүлэн 1,103.5 сая төгрөгийн зардал гаргаж, 1.0 сая төгрөгийг үлдэгдэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт хамааралтай асуудал илрээгүй.

### 3.8 Аудитын гол асуудал

- ✓ Ажилчдад олгосон цалингийн дүнг нийгмийн даатгалын тайланд үнэн зөв мэдээлээгүй 16.9 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
- ✓ ХХОАТ-ын хөнгөлөлтийн зөрүүний тооцоог жилийн эцэст хийгээгүй, 28 ажилтны хөнгөлөлтийг түүвэрлэн шалгахад 258.1 мянган төгрөгийн зөрүү илэрсэн;
- ✓ Түрээсийн орлогыг анхан шатны баримтыг үндэслэн орлогоор хүлээн зөвшөөрч бүртгээгүй, 0.5 сая төгрөгийн түрээсийн орлогыг санхүүгийн тайланд авлагаар бүртгээгүй орхигдуулсан, төсөвт төвлөрүүлэх 40 хувийн орлогыг 0.4 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн мэдээлсэн боловч нэмэлт дансны таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг хугацаа хоцроож 12 сард мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар 1 зөвлөмж, 1 албан шаардлага, 1 төлбөрийн акт хүргүүлснийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 443.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 425.2 сая төгрөгийн алдааг залруулж, 0.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 17.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, шилэн данстай холбоотой зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

### 4.2.1 Залруулсан алдаа

ЭМД-ын сангаас авах 425.2 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгалгүй орхигдуулсан алдааг залруулав.

### 4.2 .2 Төлбөрийн акт

Түрээсийн орлогыг 0.9 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн зөрчилд төлбөрийн акт тогтоов.

### 4.2.3 Албан шаардлага

Нийгмийн даатгалын тайланд хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлого /цалин/-ыг анхан шатны баримтаас 16.9 сая төгрөгөөр илүү тайлагнаж нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг үр ашиггүй зарцуулсан, цалингаас суутгасан ХХОАТ-ын хөнгөлөлтийн зөрүүний тооцоог жилийн эцэст хийгээгүй 0.3 сая төгрөг, нийт 17.2 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлэв.

### 4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

*Илрүүлэлт:*

Шилэн дансны цахим хуудсанд нэмэлт санхүүжилтийн дансны таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг хугацаа хоцроож 12 сард мэдээлсэн байна.

*Өгсөн зөвлөмж:*

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасан зарчмыг баримтлан шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв, иж бүрэн байршуулж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 5 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН АСУУДАЛ** | | | | | | | | | | | |
| 1 | Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлэг | 1 | 443.3 | 1 | 425.2 | 1 | 0.9 | 1 | 17.2 | 0 | 0 |
| **САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ** | | | | | | | | | | | |
| 1 | Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлэг | 1 | 0 | | | | | | | 1 | 0 |
| **Дүн** | | **3** | **443.3** | **1** | **425.2** | **1** | **0.9** | **1** | **17.2** | **1** | **0** |

# ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
# АКТ

2022 оны 02 сарын 25 өдөр Дугаар 06/А2370449 Чингис хот
ХЭА-2022/27/НА-СТА-ТШ13

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Төрийн өмчийн байр түрээслүүлсний орлогын 912.0 мянган төгрөгийг төсөвт дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоолын 2-д "Түрээсийн орлогоос улсын төсөвт төвлөрүүлэх хэмжээг нийт орлогын дүнгийн 40 хувиар тогтоосугай" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т *"Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно."*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох " журмын 4.2.3.2 -д "төрийн болон орон нутгийн эд хөрөнгийг түрээслүүлсэн, ашиглуулсны төлбөр болон борлуулсны орлогыг дутуу төвлөрүүлсэн, эсхүл төвлөрүүлээгүй " гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Төсөвт дутуу төвлөрүүлсэн 912.0 мянган төгрөгийг аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх

2. Актын биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга Д.Оюунгэрэл, ерөнхий нягтлан бодогч Д.Өсөхгэрэл нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТОР Х.ЕРКЕГҮЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ОЮУНТУЯА

Монгол Улс, Чингис хот, 3-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 98601199

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2022 оны 02 дугаар сарын 25 Дугаар 27/А2370449 Чингис хот
ХЭА -2022/27/НА-СТА-7Ш3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгалын тайланд хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогын дүнг анхан шатны баримт болох ажилчдад олговол зохих цалингийн дүнд үндэслэн үнэн зөв тайлагнаагүй, жилийн эцэст ХХОАТ-ын хөнгөлөлтийн тооцоог хийгээгүй зэрэг нийт 17.2 сая төгрөгийн зөрүүтэй илэрхийлж нягтлан бодох бүртгэлийг зохих ёсоор хөтөлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нийгмийн даатгал болон ХХОАТ-ын тайланд ажилчдын цалин, татварын хөнгөлөлтийг зөрүүтэй илэрхийлсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга Д.Оюунгэрэл, ерөнхий нягтлан бодогч Д.Өсөхгэрэл нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТОР Х.ЕРКЕГУЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ОЮУНТУЯА

2317144297
СЮА0046 9074082

Монгол Улс, Чингис хот, 3-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 98601199